

ЗҮҮНГАРЫН ТӨР УЛСЫН СТАТУС

И. Саруул
/МУИС-ийн НШУС-ийн багш/

Өгүүллийн товч: Зүүнгарын түүхийн судалганаас үзэхэд хэдэн онд байгуулагдсан, хэн үндэслэсэн, хэзээд нь улс болж хөгжсөн асуудал эрдэмтэн судлаачдын дунд санал зөрүүтэй байна. Зарим нь Хархул ноён үндэслэсэн, зарим нь Баатар хунтайж, Галдан бошогт гэх мэтээр авч үзсэн байна. Түүхэн өрнөлтийг нягтлах аваас Зүүнгар нь Хархул, Баатар хунтайжийн үед аймаг, Галдан бошогтын цагт ханлиг байгаад Цэвээнравдан хунтайжийн (1697 оноос) үед улс болж хөгжсөн төр улс – нийгмийн статустай байна.

Түлхүүр үг: Аймаг, ханлиг, улс.

Сүүлийн хэдэн жил эрдэм шинжилгээний хурал, ярилцлагад оролцож байхад олонтаа хөндөгдөж манай тэргүүлэх эрдэмтдээс “Зүүнгарын хаант улс” нэртэй ийм улс оршин байсан уу? Түүхэн оноосон нэр мөн үү? Нийгмийн байгууллын хувьд улс мөн эсэх? Ямар хэлбэрийн улс байсан? Хэдэн онд байгуулагдсан? Хэн үндэслэсэн? зэргээр шил дараалан асууна. Дунд сургуульд суралцагсад, гадаадын судлагчдаас Монголын дундад зууны түүхэнд Зүүнгарын хаант улс гэж гарч байгаа нь тухайн үеийн Монгол улсад хамаарахгүй юм уу? гэнэ. Эгэл уншигчид маань ч Зүүнгарын улс гэж бас нэгэн улс байсан юм уу? гэж хөндөнө. Тиймээс академич Ч. Далай: - “Зүүнгарын улс хэзээ байгуулагдсан, ямар зохион байгуулалттай улс байсан талаар дотоод гадаадын олон эрдэмтэд янз бүрээр л тайлбарлажээ” (5.т.134.) гэжээ. Энэ бүхэн нь Монголын түүхийн судлалд Зүүнгар нь улс байсан эсэх асуудал хараахан тодорхойлогдоогүйтэй холбоотой юм. Монголын түүхийн янз бүрийн үе шатанд ноёд язгууртны эзэмшлийг улсаар нэрлэсэн бүрдэл олонтаа тааралдана. Тэднийг чухам улс гэж үзэх үү? Эсвэл овог аймаг, ханлигийн статустай эсэхийг нягталж тодорхойлох шаардлагатай. Академич Ж. Болдбаатар: - “Түүхийн судалгаанд X-XII зууны Монголын ханлиг, аймгуудын төр улсын бүрдэл үүсгэж байсан уу? үгүй юу? гэдэг асуудлаар янз бүрийн санал дэвшүүлэх болов. Тухайлбал: 1. Хамаг Монгол, Хэрэйд, Найман зэрэг аймаг ханлигууд нь төр улсын бүрдлийг бий болгосон (Ч. Далай); 2. Эдгээр ханлиг, аймгууд нь төр улсын бүрдлийг бий болгоогүй “толгойлогчийн эзэмшил” буюу chiefdom байсан (Кембриджийн эрдэмтэд, Ш. Бира зэрэг); 3. 1189 онд Тэмүүжин Хамаг Монгол “чифдомын” хэлбэрээс гарч, төр улсын чамбайрсан бүрдлийг бий болгож, тийм ч учраас бусад Монгол ханлиг, аймгуудыг оройлон нэгтгэж чадсан (Ж. Болдбаатар, түүний шавь нар) гэжээ (45.т.5.). Эл үндэслэлийг ёсчилбол тухайн бүрдлийг улс төр, эдийн засгийн түүхэн цаг үе, харилцаа холбоонд нь уялдуулж статусыг нь тодорхойлох санаа бөгөөд Зүүнгар ч мөн ийм байдлаар хамаарна.

Аливаа төр улсыг тэмдэглэх томъёолол бол үндэсний ухамсрын төлөвшил, ертөнцийн үзэл баримтлал тул түүхэн тодорхой агуулгатай байх ёстой, шинжилгээ судалгаанд нотлогдоогүй хирд зохиох явдал баймгүйг эрдэмтэд ямагт анхааруулна. Монголын дундад зууны түүх бичлэгт Зүүнгарын нутагт оршисон баруун монгол буюу ойрадын байгуулсан Зүүнгарын улсыг ямагт төр улсын хэлбэртэй тогтносноор бичжээ.

Түүнийгээ баталгаажуулж “Зүүнгарын хант улс”, “Зүүнгарын хаант улс”, “Ойрадын хант улс”, “Ойрадын хаант улс” нэр томъёоллыг хүртэл үүсгэсэн байна. Харваас хүчирхэг аугуу гүрэн мэт ойлгогдох нь эргэлзээгүй боловч ч түүхэн төр улсын тогтнолын утга агуулга ямагт зөрчилдөнө. Иймд Зүүнгар нь шууд улсын хэлбэрээр хөгжсөнгүй, анхлан овог аймгаас гараагаа авч ханлигт дэвшсэн, хөгжлийнхөө оргилд төр улсын төвшинд мандсан түүхийг тодруулах байна. Зүүнгарын хаант улс нэр томъёоны бүтцэд үндсэн ойлголт үг нь “улс” болж, түүнээс шалтгаалан “хаант”, “зүүнгар” үгсийн агуулга хавсарна, төр улсын статус нь аймаг, аймгийн холбоо, ханлиг, улс гэсэн нэр томъёолол, эдгээрийн агуулгаар тодорхойлогдоно.

Манай түүх бичлэгт Зүүнгарын улсыг чорос аймгийн Хар хул тайж үндэслэсэн, удаад нь Баатар хунтайж байгуулсан, дараагийнх нь Галдан бошогт цогцлуулсан, эцэст Цэвээнравдан, Галданцэрэн нарын үед төр улсын төрхтэйгээр Төв Азид мандсан гэсэн хувилбарууд байна. Цөм манай эрдэмтэн судлаачдын санаа бодол, эргэлзээ шийдлийн хувь өнгө аястай холбогдсон нь төвөггүй ажиглагдана.

Хархул тайж Зүүнгарын улсыг байгуулсан саналын хувьд Намсрайжавын Алтаншаа: - “Хар хул бол Зүүнгарын хан улсын хамгийн эхний суурийг тавьсан хүмүүн болох юм” (21.т.144.) гэсэн санаа мэр сэр тааралдаж байна. Феодалын бутралаар нийт Монгол улсад төр улс, нийгмийн байдал тогтворгүй байсан цагт баруун жигүүрт XVII зууны 20-30 оны үед Чоросын Хар хул тайж нутаг орныхоо овог аймгуудыг нэгтгэн хүчирхэгжиж, Ойрадын тэргүүлэх аймгуудтай эн зэрэгцэн нэр нөлөө нь өсчээ. Тэр үед Ойрадад чорос, торгууд, хошууд, дөрвөд хэмээх дөрвөн их аймаг тэргүүлсэн байвч хэн хэндээ харъяалагдахгүй, тус тусдаа харъяатаа захирна. Тэднийг нэгтгэн холбосон зүйл бол аймгуудын хооронд тогтмол хуралдаж дотоодын хэрэг зарга шийтгэх, гадны халдлагыг хамтран эсэргүүцэх зэрэг чухал хэрэг явдлыг зөвлөдөг аймгийн чуулгантай байжээ. Зүүн Монголын аймгууд мөн ийм чуулгантай байсан, Ойрадын чуулгантай харьцуулахад тогтмол ажиллагаагүй байснаараа ялгарна. Н. Алтаншаа: - “Энэхүү сул зохион байгуулалтыг *чуулган* гэдэг бөгөөд *ойрадын холбоо* гэж бас хэлдэг юм” (21.т.141.) хэмээн тодорхойлжээ. Хар хул тайж чорос аймгаа мандуулсан тэр эрчээрээ уг чуулганыг тэргүүлэхээр ширүүн тэмцэвч сэтгэлчлэн бүтсэнгүй. Монголын олон овог аймаг хоорондын эрх мэдэл булаалдсан дотоодын тэмцэл байснаас үзвэл Хар хулын толгойлсон чорос нь ойрадын нэгэн аймаг байсан нь тодорхой, улсын зэргэмжинд хүрч хөгжих хүртэл зай ч байж, лай ч байжээ.

Баатар хунтайж Зүүнгарын улсыг байгуулсан гэсэн нь хоёрдох үндэслэлийн хувьд БНМАУ-ын түүхийн П ботид: - “Баатар хунтайж 1630 хэдэн онд Ойрадын холбооны хүчирхэг улс байгуулжээ” (1.т.71.); Академич Н. Ишжамц: - “Зүүнгарын хаант улс ХҮП зууны 30-аад оны үед үүсэн тогтножээ” (3.т.14.); И.Я. Златкин: - “Зүүнгарын улсыг ойрадын Баатар хунтайж 1635 онд байгуулсан (13.т.71.); Академич Ч. Далайн бичсэн зүйлс: - 1. “Баатар хунтайжийн үед Зүүнгар улс нэгэнт байгуулагдсан гэж үзэх нь ч олонтаа тааралдана. Үүнд нэг их буруу байхгүй мэт. Учир нь гэвэл Баатар хунтайж оросын хаантай харилцахдаа хоёр

улсын хэмжээнд харилцаж байсан. Оросын цагаан хаан ч ойрад улс гэдгийг хүлээн зөвшөөрч элч төлөөлөгч илгээж байсан байна (5.т.134.); 2. "Баатар хунтайжийн үед Ойрадын холбооны улс бараг байгуулагдсан. Тэр ч байтугай Зүүнгарын хаант улс үндсэндээ байгуулагдсан" (5.т.128.); 3. "Баатар хунтайж Зүүнгарын хаант улсыг байгуулах үндсэн нөхцлийг бүрдүүлж өгсөн" (5.т.121.) гэх мэтчилэн; Намсрай: - "Тэр /Галдан бошогт – И.С./ эртнээс уламжилсан ойрадын чуулган зуршлыг хүчингүй болгож, төвт эрх төвлөрсөн Зүүнгар хагаант улсыг ойрадын түүхэнд анхдугаар удаа цогцлон байгуулжээ" (6.т.64) гэсэн эрдэмтдийн бичсэн олон зүйлс заалттай учирч байна. Тэдгээрт "Ойрадын холбооны хүчирхэг улс", "Ойрадын хаант улс", "Зүүнгарын хаант улс" нэр томъёолол нь эрхгүй анхаарал татна. И.Я. Златкин "Ойратское государство" (13.т.319.) гэжээ. Зүүнгарт нийт ойрад угсаатан хамаарч байсангүй, зөвхөн Зүүнгарын нутагт оршин байсан тэр л хэсэг харъяалагдсан тул "Ойрадын холбооны хүчирхэг улс" гэсэн нь зохицошгүй. Хөх нуурт суурьшсан Гүүш ханы хошууд болон Ижил мөрөнд очсон Аюук ханы торгууд нар тусдаа л тогтнож байжээ. Эх түүхийн бодит утга агуулга зөрчилдөх бөгөөд ингэж их улсын томъёолол оноох нь юу л бол. Эдгээр зэрэг үндэслэлээр "Ойрадын хаант улс", "Зүүнгарын хаант улс" нэр томъёо нь зохиомол гэлтэй, тэр тусмаа Баатар хунтайжийн үед төр улс бүрэлдсэнгүй, Зүүнгарт ч хаан байсангүй.

Дийлэнх нөхөд Баатар хунтайжийн захирсан зүүнгар аймгийг ийнхүү өргөмжилж бичсэн хэдий ч нөгөөтэйгүүр бас үгүйсгэсэн зүйл цөөнгүй бий. Үүнд:

- Академич Ч. Далай: - "Гэхдээ тэр үед ойрад монголын төрийн эрх мэдэл нэг хүний гарт биш, чуулганы хан нь хоёр хүн байсан болно. Хошуудын Очирт сэцэн тайж, Баатар хунтайж нар хамтран чуулганы эрх барьж байсан бөгөөд тухайн үеийг "хоёр тайжийн засаглал" гэдэг. Түүнээс гадна ойрадчууд бүрэн нэгдээгүй, ойрадын зарим ноёд хувиа бодож албат ардаа чирэгдүүлэн, эх нутгаасаа ийш тийш нүүн одох нь их болсон байв. Ойрадын нутагт дайн дажин тасралтгүй гарч нутаг бэлчээр, мал сүрэг, өмч хөрөнгөө өөр хоорондоо булаацалдах нь зогсоогүй байв. 1640 оны "Монгол-Ойрадын цааз"-ын үзэл санаа Халхад ч, Ойрадад ч гүйцэд хэрэгжихгүй байлаа. Өөрөөр хэлбэл, Эсэн хаанаас хойш дөрвөн ойрад гүйцэд нэгдэн нэгэн жолоонд орж хараахан чадаагүй байсан үе юм" (5.т.134-135.) гэсэн байна;

- Доктор С. Цолмон: Нэгд, - "Эрдэнэ Баатар хунтайж ойрадын нилээд хэсгийг захирч байсан боловч улсынхаа дотор хунтайж цолтой хоёрдох хүн нь байсан юм. 1636 онд ойрадын Төрбайх гүүш хан халхын Цогт хунтайжийн эсрэг, мөн хошуудын Очирт сэцэн хан хасагийн Янгир султан, халхын Алтан ханы эсрэг тус тус цэрэглэхэд тэдний удирдлагын дор цэргийн хүчин хавсарч явсан. Ойрадаас гадагш цэрэглэхэд ямагт Төрбайх гүүш хан болон Очирт сэцэн хан нарын удирдлагын дор хоёрдох хүмүүс болж байсан" (22.т.41.); *Хоёрт*, - "Хэрэг дээрээ тэдний (Хар хул ноён, Баатар хунтайж - И.С.) үед ойрадын газар нутаг, хүн амын ихэнх хэсэг тэдний удирдлагад ороогүй, ойрадын чуулган дарга хошуудын Очирт сэцэний мэдэлд байсан юм" (22.т.41.); *Гуравт*, - "Хар хул, Эрдэнэ баатар нар хунтайж

хэмээх цолтой ба тэдэнд "хан" цол байгаагүй" (22.т.41.); Дөрөвт, - "Иймээс бид Зүүнгарын хаант улсыг Эрдэнэбаатар хунтайж 1635 онд бус, Галдан Сэнгийн ор залгасан 1671 он бус, харин Галдан хошуудын Очирт сэцэн ханыг цохиод бүх ойрадын нутгийг мэдэлдээ оруулсан 1676 оныг Зүүнгарын улс жинхэнэ ёсоор байгуулагдсан он мөн гэж үзэж байна" (22.т.42.) гэжээ;

- Боржигдой Оюунбилиг: - "Хошуудын Очирт сэцэн тайж, чорос аймаг угсааны Баатар хунтайж хоёр баруун монголчуудын зүүнгар, баруунгарын хэсгүүдийг ойрадын чуулганд нийлүүлсэн боловч аймгийн тэргүүлэгч ноёд нь урьдын хэвээр тус тусдаа засаглаж байжээ. Тэр үеийн нилээд хүч нөлөөтэй ноёдууд бол хошуудын Хөндлөн-Уваш, Очирт сэцэн тайж, чоросын Баатар хунтайж, дөрвөдийн Омбо дайчин хошууч, хойдын Сүлдэн тайж зэрэг байжээ. Эдгээр нь хувь хувийн нутагтаа нутаглаж, харилцан захирагдахгүй чуулганы хэлбэрээр байжээ" (19.т.288.) гэв;

Монгол улсын төрийн түүхийн эрдэмтэн М. Санждорж: - "Нэгэнт манжийн эрхшээлд орсон ба түүний харъяат болсон Зүүн Монголтой нэгэн улсын хүрээнд багтан байх аргагүй болсон нь ... дотор зуурын тэмцэл юм. Бүхэллэг талаас нь үзвээс эргэлзээтэй байна. Өөрөөр зүүн баруун (ойрд) хоёр Монголыг Баатар хунтайж болон Галдан бошогтын Зүүнгарын хаант улсыг хүртэл тус тус бие даасан улс хэмээн үзэж боломгүй. Энэ хоёрыг гадаад улсын нүдээр харахуйд нэг л улс байжээ. Энэ хоёрын хооронд гарч байсан тэмцэл мөргөлдөөн нь нэг нь нөгөөгөө эзлэхийн төлөө бус, нэг улсын хүрээнд эрх мэдэл, ноёрхлын төлөө, хаан эрхийн төлөө тэмцэл байжээ. Ойрдын Эсэн Зүүн Монголыг эрхэндээ оруулсаныг, Зүүн Монголын Батмөнх, Түмэдийн Алтан хаан, Хутагт сэцэн хунтайж, Халхын Автай сайн хан нар ойрдыг эрхэндээ оруулсаныг нэг нь нөгөөг эзэлсэн хэмээгдэхгүй, төр улсаа нэгтгэн захирсан хэрэг гэж тэр үедээ ойлгож байсан бөгөөд одоо ч ингэж ойлгогдож байна. Баруун Зүүн хоёр Монголын тус тус бие даасан байдал эдүгээгийн ойлголтоор холбооны (федерацийн) улсын дүр төрхийг санагдуулам байгаа юм" (33.т.83.) гэжээ. Эдгээр заалт зэрэг эрдэмтдийн хэлсэн бүхэн нь Зүүнгарт хараахан улс бүрэлдэх нөхцөл үндэслэлгүй, Монгол улсын бүрэлдэхүүний аймаг ханлигийн статусаар тодорхойлжээ.

Нэгэнт улс гэсэн үг хаа сайгүй хэрэглэгдэх тул агуулгыг нь тодорхойлох нь зүйн хэрэг, Монголын түүх бичлэгт улс үгний хоёр утга санаа илэрч буй. Нэг нь өнөөдрийн тусгаар тогтносон улсын хэлбэрээр, нөгөө нь монгол ойлголтоор алив ноёны хувь ард иргэд, харъяат албат, эзэмшлийг заах тул агуулга, утга санааны нилээд ялгаатай. Түүнийг төр улсын хэлбэрт оруулж тусгаар улсын хэлбэрээр тайлбарлаж хэрхэвч боломгүй, сурвалж бичигт ноёдын хувь улс буюу аймаг гэсэн санаа нь ойлгомжтой, нягталсан ч ийм үндэслэл тавигдахгүй. Зүүн Монголын аймгуудыг Түшээт хан улс, Засагт хан улс хэмээн Монголын түүхэнд бичдэг, тэдэнтэй Галдан бошогтын үед Зүүнгар хант улс болж зэрэгцжээ. Монголын феодалын бутралын цагт Монгол улс төв засаглалгүй, бүрэлдэхүүний хэсгүүд бие биенээсээ харилцан хамаарахгүй, улсын зэргэмжинд дэвжсэн их аймаг ханлиг тул захирагч гагц эзэнтэйн хувиараар хантай, харъяатыг нь хураангуйлан улс гэж нэрлэж байжээ.

Боржигдой Оюунбилиг, Н. Хасбагана, Сэцэнт нар Галдан бошогтын захирсан улсыг ханлиг захирсан гэж үзэж, Боржигдой Оюунбилиг нь хувь номныхоо гарчигт “Зүүнгар ханлиг Түвд зүг өнгөлсөн нь” (19.т.3,232.) гэсэн бол Н. Хасбагана, Сэцэнт нар Галдан бошогтын үед Зүүнгар нь аймаг байаад Цэвээнравдангийн үеэс ханлиг болсон гэж үзжээ (46.т.132-163.). Ханлиг эдэг нь улс байгуулагдахын өмнөх шат, урдчилсан нөхцөл бүрдэлт, алив улсын бүрэлдэхүүний нэгж бие даасан хэсэг болно. Дотоод засаглалын олон чиглэлээр эрх мэдлээ бие дан хэрэгжүүлэх боловч үндэсний аюулгүй байдалд улсын төв засаг төрөөс хамаарч захирагдана, тусгаар тогтнол буюу улс бус юм. Баатар хунтайжийн санаачлагаар байгуулагдсан 1640 оны Монгол-Ойрадын цааз бичигт зүүн, баруун монголчууд нэгдмэл Монгол улс байсныг хуульчлан баталсан, түүнийг Галдан бошогт ч хоёр зүйл нэмж засаглалдаа хрэгжүүлсэн нь мөн харуулна.

Галдан бошогтын ханлигтаа хэрэгжүүлсэн шинэтгэл Зүүнгарын улсыг төр улсын зэргэмжинд хүгэж хөгжүүлсэн санаагаар батлахыг оролдсон зүйл бас бий. Тэр ч байтугай Зүүнгарт засагзахиргааны нэгж болох отог, анги байгуулсан гэж С. Цолмон, А. Очир нар үзжээ. С. Цолмон: - “Юуны өмнө Галдан бошогт чуулганы зохион байгуулалтыг эвдэж засаг захиргааны шинэ зохион байгуулалт хийсэн” (22.т.41.) гэж бичжээ. Галдан бошогтын шинэчлэл болсум хийдэд зориулсан гурван отог байгуулснаар хязгаарлагдаж, үндсэндээ Зүүнгарын хууин тогтолцоог хадгалж байв. Галдан бошогтын хэрэгжүүлсэн шинэтгэлийг Цэвээнравдан, Галданцэрэн нарын төр улсын байгуулалтай харьцуулбал орон нутгийг засах төдий нийлхэн харагдана.

Академич Ш. Бирагийн санал Галдан бошогтын Зүүнгарыг их оновчтой тодорхойлсон санагдана. Тэр нь: - “Эртний монголчуудын дунд хан цолтон эрх дархтай болохынхоо хэрээр Монголын нийгэмд төр улс бүрэлдэх үйл явцад үлэмж тус нэмэр болсон байна. XII-XIII зуунд Монолын нутагт Хэрэйд, Найман, Мэргэд, Татар, Хамаг Монгол (Онон, Хэрлэн, Туул гурван гурван голын эхний монголчууд) зэрэг иргэдийн томоохон нэгдлүүд буюу овог аймгуудын холбоод буй болж, тэдгээрийг хан нар, тэдэнтэй тэнцэх цолтон (ван, тигитхури, бек зэрэг) тогойлж байжээ. Тэдгээр хадын толгойлж байсан иргэдийн нэгдлүүдийг бид ханлигууд хэмэн нэрлэдэг. Гэхдээ тэдгээр ханлигийг жинхэнэ улс байсан хэмээн тооцож болохгүй. Зарим эрдэмтэн, ялангуяа манай монголын түүхчид Чингисийн хаант улс байгуулагдахас өмнөхөн Монголд байсан улсууд-ханлигуудыг (Хэрэйд, Найман, Хамаг Монгол зэрэг) жинхэнэ улс байсан мэтээр үзэж иржээ. Сүүлийн үеийн судалгааны дүнгээс үзэхэд тэдгээр ханлигууд бол хэдийгээр улс, улс иргэд хэмээн нэрлэгдэж байсан ч зөвхөн төр улсын өмнөх улс төрийн бүрдлүүд төдий байсан хийгээд тэдгээрийг одоогийн антропологийн нэр томъёогоор чифдом (chiefdom) буюу монголчилбоос ахлагчийн эзэмшлийн нээн өвөрмөц хэлбэр байсан хэмээн үзэж болно” (17.т.24-25.) гэжээ. Энэхүү санаагаар бол Галдан бошогт Зүүнгарын улсыг байгуулсан гэсэн үндэслэлүүд нь учир дутагдалтай Өгөөд Монгол улсын бүрэлдэхүүний хэсэг, баруун жигүүрийн томоохон тэргүүлсэн аймаг буюу ханлигийн хэлбэрээр тогтнож байжээ.

Академич Н. Ишжамцын түүх судлалаар бол: - "Х1Y зууны дэд хагаст Тогоонтөмөр (1370 онд нас барсан), Билигт (1370-1378), Төгстөмөр (1378-1388) хааны үед Монгол улс Зүүн Монголын зургаан түмэн, Баруун Монголын дөрвөн түмнээс бүрдэж, нэгдмэл байдлаа хадгалж байв. ... 1399 онд дөрвөн Ойрад нь Зүүн Монголоос тусгаарлан салснаар Монголд феодалын бутрал эхэлж, үе үе хүндхэн байдалд орж байжээ. ... Зүүн, Баруун түмэн, Ойрад гэж Монгол улс гурван том ханлиг буюу жижиг хант улсууд болон хуваагдаж байсан нь нэгдмэл байдлыг алдагдуулж, түүний улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болсон юм. ... Ойрадыг бага ханы эрх мэдэл бүхий тайш цолтон захиран тусгаарласан байв" (18.т.63.). Үүнээс үзэхэд ойрадад ханлиг аль хэдийнээ байгуулагдсан байсан, түүний ахлагч нар нь солигдож л байжээ. Тэгвэл Хархул, Баатар хунтайж, Галдан бошогт нарын хэн ч ханлиг, эсвэл улс байгуулж байгаагүй байна. Мөн улс болсны нэг шалгуур нь хан цолноос хамаарахгүй мэт. Галдан бошогтоос өмнө ойрадад чуулган даргын зэрэгцээ хэдэн ноёд хан цолтой явав. Хан цолыг Түвдээс олгож, тэдний эрх баригсад өөрсдийг нь хамгаалах түшиг найдвар тавьсан монгол ноёдод ая тал зассан цол төдий юм. Эс таалагдсан нөхдөд гар татна. Тэр энэ газар орон, ард түмнийг захир гэсэн зүйл бус, соёрхол төдий юм. Галдан бошогт, Цэвээнравдан, Галданцэрэн нар бүгд хан цол түвдээс хүртэцгээжээ.

Нэгэнт Хар хул ноён, Баатар хунтайж, Галдан бошогтын үед улс бүрэлдсэнгүй нь тодорхой тул Зүүнгарын улс дотоод гадаад хүчин зүйлээр нөхцөлдөж 1697 оноос хойш байгуулагджээ. Төв Азийн улс төрийн хүндхэн байдал, тэр тусмаа Хаант Орос, манжийн Чин гүрний түрэмгийлэл, дотоодын эв нэгдэл суларсан байдал төр улсын зохион байгуулалтанд түргэн шилжихэд шулуутгаж Зүүнгар нь орь ганцаар тогтнож хэнээс ч хараат бус бие дааж оршиход хүрчээ. Өвөр, Халх Монгол эзлэдэхэд Монголын төр улсын голомт Зүүнгарт шилжиж даруй 67 гаруй шахам жил хадгалагдаж 1758 онд мөхөөгджээ. Галдан бошогт дарагдмагц зүүнгарын ойрадууд Цэвээнравданы мэдэлд харъяалагдаж, төвлөрсөн төв удирдлагатай, гадны аюул занал нүүрлэхэд эрхгүй нэгдэн нягтрах, хамтран оршин тогнох төр улсын зохион байгуулалтанд шилжсэн явдал болно. Энд төр засгийн удирдах байгууллага байгуулагдан удирдаж, төрийн албыг гүйцэтгэх албадууд ажиллаж, захирах захирагдах ёсны түшмэл, албан тушаалын нарийн бүтэцтэй болжээ. Дээрээс дорогш гүйцэтгэх арван, хорин, дөчин гэх мэт чухал юм. Тэр байтугай тун шаардлагатай мэрэгжлийн үр бүтээмжийн алтжин, буучин, захчин зэрэг нь тодорхойлно. Улс тогтнох бас нэгэн чухал үндэс бол байнгын цэргийн ангийн бүтэц бүрэлдэж, байршлын онцгой хөдөлгөөнт, нэгдсэн удирдлагатай цэрэг дайны ажиллагаанд нягтруулсан нь Зүүнгарыг улс гэж үзэх хангалттай үндэслэл болно. Цэвээнравдангийн хэрэгжүүлсэн шинэтгэл зохион байгуулалт бүхэлдээ төр улсын тогнолыг агуулжээ. Энэ бол Галдан бошогтын улс гэсэн ханлигийн оршилтоос мөн чанарын эрс ялгаатай тогтнол юм.

Зүүнгарын улс цаг хугацааны хувьд хэдэн онд байгуулагдсан талаар ном зохиолд хэдэн хувилбар буй. Үүнд: Академич Н. Ишжамц: - "Зүүнгарын хаант улс ХҮП зууны 30-аад

оны үед үсэн тогтножээ” (3.т.14.); И.Я. Златкин: - “1635 он бол нийтээр зөвшөөрөн хүлээсэн Зүүнгарын хаант улс байгуулагдсан анхны жил байсан” (13.т.151.); С. Цолмон: - “Иймээс бид Зүүнгарын хаант улсыг Эрдэнэбаатар хунтайж 1635 онд бус, Галдан Сэнгийн ор залгасан 671 он бус, харин Галдан хошуудын Очирт сэцэн ханыг цохиод бүх ойрадын нутгийг мэдэлдээ оруулсан 1676 оныг Зүүнгарын улс жинхэнэ ёсоор байгуулагдсан он мөн гэж үзэж байна” (22.т.42.); Академич Ч. Далай: - “1678 оныг Зүүнгарын хаант улс байгуулагдсаны анхны жил хэмээн үзэж болох ажээ” (5.т.141.); Намсрай: - “Галдан нь Зүүнгараа ноёрхуулсан хагаант улсыг байгуулсан тул 1678 он нь хэлхээнгүй Зүүнгарын хаант улсын оршин тогтносон анхны жил байжээ” (6.т.95.) зэрэг болно. Тэхлээр эдгээрийн аль нь ч нийцэмгүй, харин Цэвээнравдан, Галданцэрэнгийн үед 1697-1755 оныг хүртэл тусгаар улын статустай манджээ.

Эцст нь санаагаа хураангуйлбаас “Зүүнгарын хаант улс”, “Ойрадын хант улс”, “Ойрадын хаант улс” нэр томъёолол бол судлаачдын зохиомол төдий, түүх бичлэгт тохирошгүй. Түүнийг залруулж: *Нэгд*, Хар хул ноён, Баатар хунтайжийн (1635-1676) цаг үеийн зүүгарыг “Зүүнгарын аймаг” гэх; *Хоёрт*, Галдан бошогтын (1676-1697) захирсан харъяатыг “Зүүнгарын ханлиг” гэнэ; *Гуравт*, Цэвээнравдангийн (1697-1727) үеэс “Зүүнгарын улс” гэвэлсая түүхтэй авцалдана.

Ашигласан ном зохиол

1. “БНМАУ-ын түүх”. Дэд боть. 1604-1917. – УБ., 1968.
2. “Монгол улсын түүх”. Дөтдүгээр боть. ХҮП-XX зууны эхэн. – УБ., 2004.
3. Ишжамц Н. Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл (Амарсанаа, Чингүнжав нарын бослого). – УБ., 1962.
4. Санждрж М. Монгол төрийн түүхээс. Гутгаар дэвтэр. – УБ., 2007.
5. Далай I. Ойрад Монголын түүх. – УБ., 2002.
6. Намсрай. Зүүн гар хаант улсын түүх. – ӨМАХХ., 1996.
7. Бичурин Н.Я. “Описание Джунгарии и Восточного Туркестана в древнем и нынешнем состоянии”. Т.1-П. – СПб., 1829.
8. Валиханов Ч.Ч. “Очерки Джунгарии”. Т.Ш. – Алматы, 1985.
9. Веселовский Н.Н. “Посольство к Зюнгарскому хун тайчжи Цэвээнрабтану капитана Ц. Унковсого и путевой журнал его за 1772-1774 годы”.
10. Иакино. “Описание Джунгарии и Восточного Туркестана в древнем и нынешнем состоянии”. Часть 1,2. – СПб., 1829.
11. Кузнецов В.С. Материалы по истории и филологии Центральной Азии. Вып.5. – Улан-Удэ, 190.
12. Моисев В.А. “Джунгарское ханство и казахи ХҮП-ХҮШ вв.” – Алма-Ата, 1991.
13. Златкин И.Я. “История Джунгарского ханства (1635-1758)”. – М., 1964.
14. Намсрай. Монгол үндэстний түүхийн мэдлэг /Манжийн цэргээс байлдан дагуулсан нь/. – ӨМБХХ., 1991.
15. Саруу И. Цэвээнравдан хаан. – УБ., 2001.
16. Саруу И. Даваач хаан. – УБ., 2004.
17. “Монголын түүхийн бага нэвтэрхий толь. Боть Ш. С-Я. – УБ., 2002.
18. “Монголын түүхийн бага нэвтэрхий толь. Боть 1. С-Я. – УБ., 1998.
19. Оюунбилиг Боржигдой. “Хошоод товчоон”. – ӨМСХХ., 1991.
20. Найда До. “Торгууд товчоон” – ШАХХ., 2000.
21. Алтаниаа На. “Ойрадын түүхэн дэх нэрт хүмүүс” – ШАХХ., 1996.
22. Цолмон С. Галдан бошогт хаан. Нийгэм, улс төрийн ажиллагаа (1644-1697). – УБ., 1994.

23. **Нацагдорж Ш.** Халхын түүх. – УБ., 2008.
24. **“Монголын түүх”.** 11 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 8-р ангид үзнэ. – УБ., 2005.
25. **“Монголын түүхийн бага нэвтэрхий толь.** Боть 3. С-Я. – УБ., 2002.
26. **Баабар.** Монголчууд: Нүүдэл, суудал. – УБ., 2006.
27. **Успенский В.** Страна Кукэ-нор или Цинхай с прибавлением краткой истории ойратов и монголов. – ЗИРГО, т.6. 1880. Стр.140-141.
28. **Буянчуулган Б.** Дөрвөн ойрадын түүх”. – УБ., 2008.
29. **Мөнхцэцэг Т.** Япон дахь Монголын судалгаа. (1990-2005). – УБ., 2006.
30. **Саруул И.** XX зууны эхэн үеийн Монголын нутаг дэвсгэр. – УБ., 2005.
31. **Намсрай.** Зүүнгар хагаант улсын түүх. - ӨМАХХ, 1996.
32. **И. Саруул. Д.** Хүүхэнбаатар. Гурван нэрийн нэг цолны учир. – “Монгол судлалын бичиг” сэтгүүл. №1. 1992.
33. **Санждорж М.** Монгол төрийн түүхээс. ХШ-Х1Х зуун. – УБ., 1998.
34. **Гонгор Д.** Халх товчоон. Боть П. - УБ, 1978.
35. **Чернышев А.И.** Общественное и государственное развитие ойратов. М., Наука. Главная редакция восточной литературы. 1990.
36. **“Циньдин хуанъюй Сиюй тучжи”.** Боть 1-5. Сянган.
37. **“Ойрад түүхэн сурвалж бичиг”.** – Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ нар эмхэтгэн тайлбарлав. - Өвөр Монгол, 1985.
38. **Очир А.** Монголын ойрадуудын түүхийн товчоон. – УБ., 1993.
39. **Паллас П.С.** Собрание исторических известий о Монгольских народах. – Спб., 1776.
40. **Руденко С.И.** К вопросу о формах скотоводческого хозяйства и о кочевниках. – Географическое общество СССР. Материалы по этнографии. Ч-1. – Л., 1961.
41. **Майский И.М.** Монголия накануне революции. – М., 1959.
42. **Горохова Г.С.** Очерки по истории Монголов в эпоху маньчжурского господства. – М., 1980.
43. **Сунь Юнь.** Сичуй цзунтун шилюз (Общее обозрение западных границ). – Тайбэй, 1965. (А.И. Чернышевийн зохиолоос ишлэв).
44. **“Циньдин хуанъюй Сиюй тучжи”.** – *“Высочайше утвержденное географическое описание Западного края”.* Т.1-5. – Сянган.
45. “Монголын түүхийн судалгааны шинэ хандлага, тулгамдсан асуудал (ХҮП-XX зууны эхэн)”. Эмхэтгэсэн: Ч. Дашдаваа, Ока Хироки. – Center for Northeast Asian Studies. Tohoku University, 2009.
46. **Н. Хасбагана, Сэцэнт.** Манжийн ноёрхол доорх Монголчууд. – ӨМАХХ., 2009.

Abstract

In historical records about Zuungar state, researchers have different viewpoints on when it was establishment, who founded it and when it became a state etc. Some of them say that it was Kharkhul Noyon who established the Zuungar state while other suggests that the prince Baatar or Galdan Boshgot established it. When we carefully examine historical processes, it seems that Zuungar was aimak in the period of prince Baatar, khanlig under Galdan Boshgot's leadership and developed as a state in its social status during the prince Tseveenravdan's period.